



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

БАТЛАВ,
САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

/Албан тушаал/



Б.УУГАНБАЯР

/Гарын үсгийн тайлал/

Б. Ууганбаяр

*У/С Шалгалтын
Зорилго Байгуулдаг*

2024 оны 01 дугаар сарын 29

Дугаар 02/11

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт
хийх тухай

Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, "Сорьцын хяналтын дүрэм", "Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улсын хэмжээнд үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийн худалдаа, түрээслүүлэгч, үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хяналт шалгалтад хамруулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулахад шалгалтын зорилго оршино.

**Хоёр. Хяналт шалгалтад хамрагдах асуудал, хүн, хуулийн этгээд,
объектын нэр**

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад нийслэл, 21 аймгийн нутаг дэвсгэрт үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийн худалдаа эрхлэгч, талбай түрээслүүлэгч, үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй 250 иргэн, хуулийн этгээдийг хамруулна.

Гурав. Хяналт шалгалтын төрөл


Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

Дөрөв. Хяналт шалгалтын арга

4.1. Хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

4.2. Шалгалтад хамрагдаж буй аж ахуйн нэгж, байгууллагыг 12.2.1 кодтой "Үнэт металл, эрдэнийн чулуун эдлэл худалдан борлуулагч иргэн, хуулийн этгээдийг шалгах хяналтын хуудас"-аар шалгана.

4.3. Улсын хэмжээнд үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийн худалдаа, талбай түрээслүүлэгч, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа иргэн, хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй эсэх, худалдан борлуулж байгаа эдлэл нь сорьцын баталгааны тэмдэг дарагдсан эсэхийг баталгаажуулах,



стандартын дагуу мөнгөн аяга үйлдвэрлэсэн эсэх, хэрэглэгчийн эрх ашгийг хангуулж байгаа эсэхийг нягтлан шалгах, тайлбар мэдээлэл авах, шаардлагатай тохиолдолд сорьцын баталгаажуулалтад хамруулна.

4.4. Шалгаж байгаа баримт материал эргэлзээтэй гэж үзвэл түүнийг заавал магадлан шалгаж, бодит нөхцөлийг хуульд заасан арга хэрэгслийг ашиглан тогтоох, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагаас лавлагаа, мэдээлэл, судалгаа, бусад материалыг гаргуулж авна.

4.5. Шаардлагатай тохиолдолд зөрчлийн нөхцөл байдлыг фото зураг, дуу дүрсний бичлэгээр баталгаажуулна.

Тав. Хяналт шалгалт хийх бүрэлдэхүүн

Шалгалтыг Сорьцын хяналтын газрын дарга, улсын ахлах байцаагч Д.Бэхбат ахлан мэргэжил арга зүйн удирдлагаар хангах бөгөөд Сорьцын хяналтын газрын болон 21 аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн сорьцын хяналтын улсын (ахлах) байцаагчид хийж гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд бусад хяналтын чиглэлийн улсын (ахлах) байцаагчид, төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллага, шинжилгээний ажилтныг татан оролцуулна.

Зургаа. Хяналт шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Хяналт шалгалтыг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэнэ.

Долоо. Хяналт шалгалтын дүнг танилцуулах

7.1. Шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтын дүнг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх арга хэмжээг авч ажиллана.

7.2. Хяналт шалгалтын явцын мэдээг сар бүрийн 20-ны дотор СХЗГ-ын Сорьцын хяналтын газарт хүргүүлнэ.

7.3. Хяналт шалгалтын дүнг хавсралт хүснэгт болон хяналт шалгалтын танилцуулгын дагуу гарган 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор СХЗГ-ын Сорьцын хяналтын газарт албан бичгээр болон d.tsendayush@masm.gov.mn хаягаар файл хэлбэрээр хүргүүлнэ.

7.4. Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга, дүнг Салбарын улсын ерөнхий байцаагч болон холбогдох удирдлагуудад танилцуулан, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

7.5. Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны "Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай" 479 дүгээр тогтоолын 12 дугаар зүйлийн 12.6, 12.7 дах заалтыг хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт шалгалтын баримт бичгийн бүрдлийг бүртгэл, мэдээллийн хяналтын удирдлагын нэгдсэн цахим системд оруулж, хяналт шалгалтын хувийн хэргийг бүрдүүлнэ.

Стандарт, хэмжил зүйн салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 12/11... дугаартай удирдамжийн хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

д/д	ААНБ,	Тусгай зөвшөөрөлтэй эсэх		Үйл ажиллагааны чиглэл	Авсан арга хэмжээ		Үнэт эдлэлүүд нь сорьцын шинжилгээнд хамрагдсан эсэх		Үнэт эдлэлүүд нь сорьцын баталгааны тэмдэгтэй эсэх		Стандартын шаардлага хангаж буй эсэх		Эрдэнэсээр хийсэн эдлэлийн бүртгэлд ашиглаж байгаа хэмжих хэрэгсэл нь хэмжих хэрэгслийн баталгаажуулалтад		Эрдэнийн чулууны чанарт тавих улсын хяналтад хамрагддаг эсэх		
		Тийм	Үгүй		Албан шаардлага /заалтын тоо/	Зөвлөмж /заалтын тоо/	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	
	Иргэн																